



## МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024. 12. 18 № 03/10385

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_ Т

### Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭМЯ/20240102089 дугаартай “Улсын гуравдугаар төв эмнэлэгт эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянгол дүүрэг/” тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон “Саммитмедикал сервис” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Саммитмедикал сервис” ХХК-аас ирүүлсэн гомдолд захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мед буян” ХХК нь тухайн барааг нийлүүлэх албан ёсны гэрээт борлуулагчийн тодорхойлолт, техникийн тодорхойлолтын үзүүлэлтүүдийн харьцуулсан хүснэгт, багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх улс, үйлдвэрлэгчийг тодорхой зааж баталгааг ирүүлэх, каталог, зураг, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч улстай засвар, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ, баталгаат хугацаанд холбогдох мэргэжлийн 2-3 эмч мэргэжилтнийг тухайн аппаратыг үйлдвэрлэгч улсад 7-14 хоногийн хугацаатай чадавхжуулах сургалтад хамруулах талаар мэдээллийг ил болгосон мэдээлэлд ирүүлээгүй, ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагын мэдээлэлд ирүүлсэн гэрээ шаардлага хангаагүй байхад шаардлагад нийцсэн гэж шалгаруулсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Захиалагчийн гэрээ байгуулах эрх олгосон “Мед буян” ХХК-ийн тендерийг гомдолд дурдсан үндэслэлээр хянан үзлээ.

1. Тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 18.1-д “Ижил төстэй бараа нийлүүлсэн туршлагыг нотлох гэрээний туршлагын шаардлага: “Шаардлагатай”. Сүүлийн 3 жилийн хугацаанд батлагдсан төсөвт өртгийн үнийн дүнгийн 80 хувиас багагүй үнийн дүнтэй ижил төстэй бараа нийлүүлсэн гэрээ доод тал нь 1 удаа. Ижил төстэй бараа гэдэг нь эрүүл мэндийн салбарын лавлаа шатлалын тусламж, үйлчилгээ үзүүлдэг эмнэлэгт ашиглагддаг эмнэлгийн тоног төхөөрөмжийг хэлнэ.” гэж заасан байна. “Мед буян” ХХК нь тухайн үнийн дүнгийн шаардлагыг хангах 2021 оны 06 дугаар сарын 30-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай байгуулсан НЭМГ/2021-БЗД-002 дугаартай ““Өрхийн эрүүл мэндийн төвүүдийн нярайн шар үздэг багаж, монитор, ЭХО, Физик эмчилгээний тоног төхөөрөмж, зүрхний цахилгаан бичлэгийн тоног төхөөрөмж, суурин

компьютер"/Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/" гэрээний мэдээллийг ирүүлсэн байна. Гомдолд дурдсаны дагуу өрхийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн салбарын лавлагаа, шатлалын тусламж үйлчилгээ үзүүлдэг эмнэлэгт хамаарахгүй талаар дурдсан байх бөгөөд тухайн асуудлыг нягтлан үзээгүй байна.

2. Тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 25.5-д "Хуулийн 22.6-д заасан баримт бичиг, мэдээллийг заавал ил болгож илгээх ба ТШЗ-ны 25.4-т заасан нь уг баримт бичгүүдэд хамаарахгүй. Захиалагч тухайн тендер шалгаруулалтад нэмэлтээр ил болгох баримт бичгийг өгөгдлийн хүснэгтэд заах ба уг баримт бичиг хүний эмзэг мэдээлэл хамаарах бол мэдээллийн эзний зөвшөөрлийг авсны үндсэн дээр тендер илгээнэ." гэж, хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэгт "Оролцогч хуульд заасан хүний эмзэг мэдээлэлд хамаарах мэдээллийг энэ хуулийн 29.2-т зааснаар ил болгохгүйгээр илгээнэ." гэж, Хүний хувийн мэдээлэл хамгаалал тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.12 дахь заалтад "'хүний эмзэг мэдээлэл" гэж хүний үндэс, угсаа, шашин шүтлэг, итгэл үнэмшил, эрүүл мэнд, захидал харилцаа, генетик болон биометрик мэдээлэл, тоон гарын үсгийн хувийн түлхүүр, ял эдэлж байгаа болон ял эдэлсэн эсэх, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийлэл, бэлгийн харьцааны талаарх мэдээллийг" гэж тус тус заасан байна. "Мед буян" ХХК нь тухайн барааг нийлүүлэх албан ёсны гэрээт борлуулагчийн тодорхойлолт, техникийн тодорхойлолтын үзүүлэлтүүдийн харьцуулсан хүснэгт, багаж, тоног төхөөрөмж нийлүүлэх улс, үйлдвэрлэгчийг тодорхой зааж баталгааг ирүүлэх, каталог, зураг, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэгч улстай засвар, үйлчилгээ гүйцэтгүүлэх гэрээ, баталгаат хугацаанд холбогдох мэргэжлийн 2-3 эмч мэргэжилтнийг тухайн аппаратыг үйлдвэрлэгч улсад 7-14 хоногийн хугацаатай чадавхжуулах сургалтад хамруулах талаар мэдээллийг тус тус ил болгохгүйгээр ирүүлсэн байхад дээрх хуульд нийцсэн гэж хянан үзсэн захиалагчийн шийдвэр үндэслэлгүй байна.


Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.1 дэх заалтыг үндэслэн захиалагчийн 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 01/1254 тоот шийдвэрийг хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын 1 дүгээр багцын үнэлгээг хуульд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 59 дүгээр зүйлийн 59.10.2 дахь заалтыг үндэслэн мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: "Саммитмедикал сервис" ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ